

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

**НЭГ.“КОВИД-19” БОЛОН БУСАД ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН
ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО:**

1.1.“Ковид-19” болон бусад халдварт цар тахлын үед эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн бодлого төлөвлөлтийн бэлэн байдлыг хангаж, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.

1.2.“Ковид-19” халдварт цар тахлын үед эрүүл мэндийн төвийноношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, хувцас хэрэгслийг урьдчилан нөөцлөх, түргэвчилсэн оношлуураар хангана.

1.3.Иргэд, олон нийтэд “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийхажлыг эрчимжүүлнэ.

1.4.”Ковид-19” цар тахлын дэгдэлтийн үед эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг эн түрүүнд шийдвэрлэж, үйл ажиллагааг тасалдуулахгүй явуулах нөхцөл боломжоор хангана.

1.5.Томуу, томуу төст өвчин, улаанбурхан, улаанууд зэрэг амьсгалын замын халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийг хамруулах ажлыг зохион байгуулна.

1.6.“Ухаалаг цахим сургалт”-ынорчинг нэмэгдүүлэн,хичээл, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж, багш нарын мэдлэг ур чадвар, эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.

1.7.Нийгмийн халамж, даатгал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдах иргэдэд банк, төлбөр тооцооны цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлнэ.

1.8.Онцгой нөхцөл байдлын үед гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.

1.9.Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийнөрх, иргэдэд үзүүлэх халамж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнийчанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.10.Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг орон нутгийн төсвийн боломжид үндэслэн төлөвлөн батлуулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, халдвар хамгааллын хэрэгслээр мэргэжлийн байгууллагуудыг хангана.

1.11.Коронавируст халдвар /Ковид-19/-ын эдийн засагт үзүүлэх нөлөөг багасгах зорилгоор Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогыг орон нутагт зохион байгуулах, орон нутгийн төсвийн хүрээнд жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж ажиллана.

ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1.Эрүүл мэнд:

Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, оношилгоо, эмчилгээг сайжруулна.

2.1.1.Хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээгтасралтгүй зохион байгуулна.

2.1.2.Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх “**Эрүүл, идэвхтэй амьдрал**”, “**Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх**”, “**Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд**”, “**Хавдрын эсрэг**”, “**Элэг бүтэн Монгол**”, “**Харшлаас сэргийлэх**”, “**Эрүүл гэр бүл-Эрхэм баян**” арга хэмжээг зохион байгуулна.

2.1.3.Хорт хавдраас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа тогтмол зохион байгуулна.

2.1.4.Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламжүйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

2.1.5.Уламжлалт эмчилгээний сувилагч, эмэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн их эмчийгажиллуулна.

2.1.6.Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсрол олгож, “**Эрүүл хүүхэд-Эрүүл Ирээдүй**” эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, эрүүлжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

2.1.7. Сумын эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж /ЭХО аппарат, биохимийн анализатор, цусны анализатор/-ийг нэмэгдүүлнэ.

2.1.8.Эрүүл мэндийн төвийг шүдний эмчээр хангаж, шүдний кабинеттай болгоно.

2.1.9.Эмч, эмнэлгийн ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллахнөхцөлийг хангаж, мэргэжлийн ёс зүй, харилцаа хандлага, хариуцлагыг дээшлүүлнэ

2.1.10.Эмнэлгийн барилгын өргөтгөлийг холбогдох байгууллагуудад уламжилж шийдвэрлэнэ.

2.1.11.Эмнэлгийн бохирын шугамын засварын зураг төсвийг хийлгэж дээд шатанд уламжлан шийдвэрлэнэ.

2.1.12.Эмнэлгийн цогцос хадгалах, салах ёс гүйцэтгэх өрөөг барьж хөргөгч, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.

2.2. Боловсрол:

Боловсролын байгууллагын орчин нөхцөлийг сайжруулж, сургалтын чанарыг дээшлүүлнэ.

2.2.1.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад “Мэргэжил сонголт” арга хэмжээг зохион байгуулна.

2.2.2.Сургууль, цэцэрлэгийн багшийн багшлах арга зүйн чадамжийг дээшлүүлэхсумын дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.2.3.Сургууль, цэцэрлэгийн сургалтын чанарыг сайжруулж Элсэлтийн ерөнхий шалгалтад оролцогчдын дундаж үнэлгээ аймгийн дунджаас, цэцэрлэгийн хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үнэлгээ улсын дунджаас дээгүүр байхүзүүлэлтийг ханган ажиллана.

2.2.4.Төрийн албан хэрэг хөтлөлтийг кирилл болон үндэсний бичгээр хослуулан явуулах бэлтгэл ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ.

2.2.5.Сурагч болон багшид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, зөвлөж туслах чиг үүрэг бүхий “**Сэтгэл зүйч мэргэжилтэн**”-ийг ажиллуулна.

2.2.6. Сум орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр амжилттай суралцаж байгаа оюутнуудыг дэмжиж ажиллана.

2.2.7. Сургуулийн Б байрны сурагчдын ширээ сандлыг шинэчилнэ.

2.2.8. Сургуулийн хичээлийн байрны өргөтгөлийг улсын төсөвт суулгах ажлыг уламжлан шийдвэрлүүлнэ.

2.2.9. Байгалийн ухааны кабинетуудыг багаж, тоног төхөөрөмж, нэн шаардлагатай хичээлийн хэрэглэгдэхүүнээр хангана.

2.2.10. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, хувилбарт сургалт, нүүдлийн цэцэрлэгийн үйлчилгээг малчин өрхийн хүүхдүүдийн дунд зохион байгуулна.

2.2.11. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийг сургаж хөгжүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2.12. Цэцэрлэг, сургуулийн хүүхдүүдийг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангана.

2.2.13. Цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд хамруулж, багш ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд тогтмол хамруулна.

2.2.14. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчны стандарт /MNS2015:6558 зөөлөн эдлэл, тоглоом наадгай хэрэглэгдэхүүн/ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

2.3. Биеийн тамир, спорт:

Хүн амын нийтийн биеийн тамираар хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ

2.3.1. Сумын иргэдийн дунд зохиогддог спортын уралдаан тэмцээнийг сэргээж, биеийн тамир спортыг хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллана.

2.3.2. “Эрүүл иргэний төлөө хамтдаа” хөдөлгөөнийг сумын хэмжээнд өрнүүлж, үр дүнг тооцно.

2.3.3. Үндэсний спортын төрлөөр хичээллэгсэд болон оюуны спорт сонирхогчдын тоог нэмэгдүүлж, хүүхэд залуучуудын дунд секц дугуйлан ажиллуулна.

2.3.4. Иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, төрийн бус байгууллагуудын идэвх, оролцоог нэмэгдүүлнэ.

2.3.5. Спорт цогцолборын барилгын их засварын зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэн их засвар хийнэ.

2.3.6. Заалны гэрэлтүүлгийг лед прожектороор сольж, спортын сургалтад шаардагдах хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана.

2.3.7. Сумын аварга шалгаруулах спортын тэмцээнийг жил бүр зохион байгуулж, аймаг, улсын хэмжээнд зохиогдох уралдаан тэмцээнд хүүхэд, залуучуудыг оролцоход нь дэмжлэг үзүүлнэ.

2.3.8. Бүсийн сумдын төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн дунд спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулна.

2.3.9. “Буган халиун”, “Боохой Данзан”-ийн нэрэмжит хурдан морины уралдаан, бөхийн барилдаан зохион байгуулна.

2.4. Соёл, урлаг:

Хүн амд үзүүлэх соёл урлагийн үр нөлөөг нэмэгдүүлнэ.

2.4.1. Хүүхэд, залуучууд, уран бүтээлчдийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэн, аймаг болон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ.

2.4.2.“Бид Сэлэнгийн үр сад”, “Эв модны наадам” зэрэг аймгийн чанартай арга хэмжээнд хүүхэд залуучуудыг оролцуулах, бүсийн сумдын хэмжээнд урлаг, соёлын хамтарсан арга хэмжээг зохион байгуулна.

2.4.3.Сумын номын сангийн фондыг нэмэгдүүлнэ.

2.4.4.Сумын орон нутгийн судлах танхимд эх орныхоо түүх соёлыг таниулах зорилгоор хүүхдийн нас, сэтгэхүйд тохирсон үзмэрүүдээр баяжуулж, цахим хэлбэрээр үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.4.5.Соёлын төвийн техник, тоног төхөөрөмжийг шинэчилж, урлагийн хувцасны нөөцийг нэмэгдүүлнэ.

2.4.6.Түүх соёлын дурсгалт газрыг сэргээн засварлах, хаягжуулах, хашаажуулах, хамгаалалтад авах ажлыг сайжруулна.

2.4.7.Соёлын төвийг лед дэлгэц, зөөврийн тайзтай болгоно.

2.4.8.Соёлын төвийг мэргэжлийн боловсон хүчнээр хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

2.5. Хүүхэд, залуучууд, гэр бүлийн бодлого:

Гэр бүл, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжиж, иргэн бүрт хүрсэн шуурхай үйлчилгээг бий болгоно.

2.5.1.Суманд хүүхэд залуучууд, эмэгтэйчүүд, ахмадын талаар баримтлах бодлогыг гаргаж хэрэгжүүлж ажиллана

2.5.2.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, “Хүчирхийлэлгүй сум” болох бодлогыг хэрэгжүүлнэ.

2.5.3.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдлэг, мэдээллийг олгох ажлыг зохион байгуулна.

2.5.4.Хүүхдийг болзошгүй эрсдэл, осол гэмтэл, гэмт хэрэг, цахим орчны нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.5.5.Хүүхдийн хүмүүжил төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, гэр бүлийн гишүүн бүрт зориулсан нөлөөллийн ажлыг зохион байгуулж, эцэг, эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ.

2.5.6.Залуучуудын хөгжих, тэдний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн холбоодын үйл ажиллагааг дэмжиж нөлөөллийн ажлыг хэрэгжүүлнэ.

2.5.7.Интернет кафе, хүүхэд залуучуудын төвтэй болох асуудлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгч, холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.

2.5.8.Жендерийн эрх тэгш байдлыг эрхэмлэсэн соёлыг төлөвшүүлэх ажлыг бүх шатны байгууллагуудад хэрэгжүүлж, хүчирхийллээс урьдчилан сэргийлнэ.

2.5.9.Сумын ТББ-уудын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана.

2.6.Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал:

Нийгмийн халамжийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангана.

2.6.1.Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн хүртээмжтэй бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.6.2.Гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ өргөжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох сургалт, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.6.3.Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санг баяжуулж, ажилгүй иргэдийн тоог бууруулна.

2.6.4.Ахмад настны хөгжил, хамгааллын үйл ажиллагааг тогтмолжуулан, хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.6.5.Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд болон малчдын нийгмийн даатгалынхамрагдалтыг нэмэгдүүлнэ.

2.6.6.Сайн дурын даатгалд хамрагдагсдын тоог нэмэгдүүлнэ.

2.6.7.Иргэн бүрийг эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлтөөр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамруулах ажлыг зохион байгуулна.

2.6.8.Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой болон зорилтот бүлгийн айл өрхүүдийн амьжиргааг дэмжих, төсөл хөтөлбөрт хамруулах ажлыг зохион байгуулна.

2.6.9.Нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай өрх, иргэнийг халамжийн үйлчилгээнд хамруулна.

ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

3.1.Хөдөө аж ахуйн бодлого

Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлнэ

3.1.1.Атрын 4-р аяныг хэрэгжүүлж, газар тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

3.1.2.Цагааннуур сумыг “Эрчимжсэн газар тариалан, мал аж ахуйн загвар” сум болгон хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

3.1.3.Малчид, тариаланчдын хамтын ажиллагааг сайжруулж, зөвлөгөөнийг зохион байгуулна.

3.1.4.Газар тариалангийн үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалан ойн зурвас байгуулах, төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор ирээдүйтэй болон нутагшсан үрийн хангамжийг нэмэгдүүлнэ.

3.1.5.Тариалангийн талбайг хашсан хашааны эзэмшил, хамгаалалтыг сайжруулж,хашаажуулах ажлыг үргэлжлүүлнэ, тариалангийн бүс малчдын зусланг заагласан хашааг малчдын оролцоотойгоор барина.

3.1.6.Хөрсний үржил шимийг хадгалан, нэмэгдүүлэх зорилгоор бордоотой тариалалт хийхийг дэмжин хяналтыг сайжруулан ажиллана.

3.1.7.Усалгаатай тариаланг хөгжүүлэх, мэргэжлийн байгууллагуудтай хамтран услах боломжтой талбайн судалгааг хийж, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

3.1.8.Сэлгээн дэх таримлын төрөл зүйл, тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлж, тэжээлийн үйлдвэрийг байгуулна.

3.1.9.Хүлэмжийн болон зоорины аж ахуй эрхлэлтийг дэмжиж, шинэ ургацын ногооны хангамжийг нэмэгдүүлнэ.

3.1.10.”Жимс жимсгэнэ” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлж иргэд, аж ахуйн нэгжид шинээр газар олгоно.

3.1.11.Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, холбогдох байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөрийн хүрээнд төмс, хүнсний ногооны зоорийг нэмэгдүүлнэ.

3.1.12.Ногоочдод хүнсний ногоо тариалахад туслах тоног төхөөрөмжийн дундын парк бий болгох ажлыг аж ахуйн нэгж байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

3.1.13.Мал сүргийг гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал угаах ванны тоог нэмэгдүүлж, эмчлэх эрүүлжүүлэх ажлыг графикт хугацаанд зохион байгуулж, хяналтыг сайжруулан ажиллана.

3.1.14.Малын үүлдэр угсаа, хээлтүүлгийн чанар хүртээмжийг сайжруулна .

3.1.15.Өндөр ашиг шимт хээлтүүлэгчийг гэрээгээр ашиглуулах, хангай хонины тоо толгой ашиг шим, үүлдэрлэг чанарыг нэмэгдүүлнэ.

3.1.16.Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх талаар сургалт сурталчилгаа, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулж, эрчимжсэн жишиг малчин өрх бий болгоно.

3.1.17.Суманд малын гаралтай түүхий эдийг боловсруулах цех бий болгож, уламжлалт аргаар арьс шир, ноос боловсруулах санал санаачилгыг дэмжиж ажиллана.

3.1.18.Сумын тариалангийн талбайн тооллого бүртгэлийг шинэчлэн хийж, кадастрын мэдээллийн санд бүртгэнэ.

3.1.19.Хөдөө аж ахуйн үтрэмийн газруудад хэмжилт хийж баталгаажуулж, газрын мэдээллийн санд бүртгэнэ.

3.1.20.Өвөлжөөний газрын тооллого, бүртгэл, хэмжилтийн ажлыг хийж, газрын мэдээллийн санд бүртгэж, гэрчилгээжүүлнэ.

3.1.21.Шинээр уст цэгийн тоог нэмэгдүүлж, алслагдсан бэлчээрийг ашиглуулна.

3.1.22.Бэлчээрийн газрын ашиглалтыг сайжруулах журам боловсруулж хэрэгжүүлнэ.

3.1.23.Малчдыг орон сууцтай болгох бодлогыг дэмжинэ.

3.2. Байгаль орчин, аялал жуулчлал:

Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2.1.Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх, сумын 2021-2025 он хүртэлх Ойн менежментийн төлөвлөгөөг баталж Сум дундын ойн анги, Хамтын эзэмшлийн ойн нөхөрлөл, Ойн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж хамтран ажиллана.

3.2.2.Ойн мэргэжлийн байгууллагуудыг чадавхжуулах, нийгмийн хариуцлагын хүрээнд сумын иргэд, өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг мод, модон материалаар хангах ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

3.2.3.Ус, хөрсийг хамгаалж, цөлжилт, бэлчээрийн доройтлоос сэргийлэн ойн зурвасыг нэмэгдүүлнэ.

3.2.4.Ойн хөнөөлт хортон шавжийн олшрол, тархалтын судалгаанд тулгуурлан устгах ажлыг зохион байгуулна.

3.2.5.Ойгоос мод бэлтгэх хуваарь, мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний олголтыг цахим хэлбэрт шилжүүлнэ.

3.2.6.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг эрчимжүүлнэ.

3.2.7.Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлж, зөв дадалд сургана.

3.2.8."Хуурчийн булаг"-ийн хамгаалалтын хашааг томруулж, булаг шандыг хамгаалах, рашаан булгийг түшиглэн амралт сувиллын газар байгуулах саналыг дэмжиж ажиллана.

3.2.9."Нянгайн" рашааныг сумын тусгай хамгаалалтад авна.

3.2.10.Сумын түүхэн дурсгалт, байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэсэн эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ. /загас агнуур, нуур, рашаан гэх мэт/

3.3. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ:

Худалдаа үйлчилгээний газруудыг эрүүл ахуй, стандартын шаардлага хангуулж, үйлчилгээний чанар, харилцааны соёлыг дээшлүүлнэ,

3.3.1.“Сум бүрт нэг үйлдвэр үйлчилгээ” арга хэмжээг төр хувийн хэвшлийн хамтарсан хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ.

3.3.2.Баялаг бүтээгч иргэдийн бие даасан, бүтээлч байдлыг дэмжих аяныг өрнүүлнэ.

3.3.3.Жижиг дунд өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх санал санаачлагыг дэмжиж ажиллана.

3.3.4.Худалдаа үйлчилгээний салбарынорчин нөхцөлийг сайжруулан үйлчилгээний соёл, хүний нөөцийг чадавхжуулна.

3.3.5.Нийтийн хоолны үйлдвэр, үйлчилгээний ажиллагсдыг давтан бэлтгэх ажлыг зохион байгуулж, сургууль, цэцэрлэгийг мэргэжлийн хоол зүйчтэй болгоно.

3.4.Хөрөнгө оруулалт, дэд бүтэц:

Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн сумын тохижилтыг сайжруулан, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ая түхтэй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.4.1.Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан түүхэн болон дурсгалт газруудыг сэргээн засварлаж, тохижуулна.

3.4.2.Сумын 100 жилийн ойг тохиолдуулан Атарчдын өндөрлөг байгуулна.

3.4.3.Цагааннуур самбарын тохижилтыг сайжруулж, Улсын тэргүүний сумын хүндэтгэлийн хаалга хийх, Зүүн гүвээнд угталт, үдэлтийн алжаал тайлах газартай болно.

3.4.4.2,3-р багийн нутаг дэвсгэрт зам тавьж гэрэлтүүлэг нэмнэ.

3.4.5.Сумын төвийн 2,4 км хатуу хучилттай замын ажлыг дуусгаж төв замтай холбоно.

3.4.6.Соёлын төвийн барилгын өргөтгөлийг хийнэ.

3.4.7.Сумын төвийн 2, 3 дугаар багийн хүүхдийн тоглоомын талбайг өргөжүүлж стандартын шаардлагад нийцүүлж тохижуулна.

3.4.8.Сумын төвийн айл өрх, барилга байгууламжийг батлагдсан стандартын дагуу хаягжуулна.

3.4.9.“Био жорлон” арга хэмжээг суманд зохион байгуулж, хөрсний бохирдлыг бууруулан нийтийн боловсон бие засах газрыг бий болгоно.

3.4.10.Сумын төвийн хашааны эмх цэгц, өнгө үзэмжийг сайжруулж, эзэнгүй хашаа байшинг цэгцэлж, газрыг дахин хувиарлаж олгоно.

3.4.11.Золбин нохой, муур устгах ажлыг жил бүр зохион байгуулж, нохойг бүртгэлжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

3.4.12.Тийрэг 3-р багийн Хонхорын хэсэгт төвлөрсөн усан сан байгуулах зураг төсвийг хийлгэж, сангаас шугам татаж байнгын усны эх үүсвэртэй болгоно.

3.4.13.1-р багийн нутаг дахь “Шүрэнгийн гол”-ын гүүр, “Салхитын даваа” , “Ноён-Уул”-ын даваа зэрэг зам давааг засварлана.

3.4.14.МСҮТ-үүдтэй хамтран техникч болон шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх арга хэмжээг ААН-үүдтэй хамтран шийдвэрлэнэ.

3.4.15.Сумын хогны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлаж, төвийн нэгдсэн хогийн цэгийн хог буулгах талбай, орох, гарах хаалгыг нэмэгдүүлж, хашаажуулна.

3.4.16.Хатуу хучилттай зам дагуу явган хүний замтай болох, хашаа барьж мод тарина.

3.4.17.Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км авто замын ажлыг барьж байгуулах ажлыг дэмжиж, хамтран ажиллана.

3.4.18.Сумын төвийн ус түгээх цэгүүдийг ухаалаг системд холбоно.

3.4.19.Суманд бохирын машинтай болно.

3.4.20.Сумын 100 жилийн ойг тохиолдуулан Соёлын төвийн өмнө талбайг тохижуулна.

3.4.21.Засаг даргын Тамгын газрын барилгын их засварыг хийх, өргөтгөл барих асуудлыг холбогдох газарт уламжлан шийдвэрлэнэ.

3.5. Санхүү, төсвийн зохицуулалт:

Төсвийн ил тод байдал, сахилга батыг хангаж, төсвийн төлөвлөлтийн оновчтой хуваарилалт, зарцуулалтыг удирдана.

3.5.1.Эдийн засгийн нөөц бололцоонд тулгуурласан төсвийн төлөвлөлтийг оновчтой зохион байгуулж, гүйцэтгэлийн хяналтын системийг сайжруулж, үр дүнгийн шинжилгээнд суурилан төсвийн ил тод байдлыг хангана.

3.5.2.Татвар төлөгчдийн бүртгэлийг сайжруулж, тайлагналт, үйл ажиллагааг цахимжуулж, хуулийн хүрээнд татвар ногдуулах боломжийг эрэлхийлж татварын суурийг нэмэгдүүлнэ.

3.5.3.Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.

3.5.4.Статистикийн мэдээ, тооллого, судалгааг үнэн, бодитой хийж, үр дүнгийн шинжилгээнд суурилсан мэдээллийг хэрэглэгчдэд боломжит хэлбэрээр тархааж, бодлогын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаанд ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.5.5.Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг бий болгож усан сан ус түгээлт, нийтийн эзэмшлийн зам талбай, гэрэлтүүлэг, нэгдсэн хогийн цэгийн асуудлыг хариуцан ажиллуулна.

3.5.6."Иргэн та эдийн засагч" арга хэмжээг суманд зохион байгуулна.

3.5.7."Сум хөгжүүлэх сан", "Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан"-гийн зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлж, эргэн төлөлтийг 90 хувьд хүргэнэ.

ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1.Нутгийн захиргаа:

Хариуцлагатай, шуурхай, нээлттэй, ил тод төрийн үйлчилгээг хүргэнэ.

4.1.1.Мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, чадахуйн зарчимд тулгуурласан ухаалаг, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлнэ.

4.1.2.Төрийн албан хаагчийн ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж, төрийн бүх шатны байгууллагад суралцагч байгууллагын соёлыг бэхжүүлнэ.

4.1.3.Төрийн үйлчилгээний цахим шилжилтийг хэрэгжүүлж, цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлнэ.

4.1.4.Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх зарчмыг баримтлан "Таныг сонсьё" арга хэмжээг төрийн бүх шатны байгууллагуудад хэрэгжүүлж, захиргааны шийдвэр гаргах, хянах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.1.5.Төр, төсвийн байгууллагуудын үйл ажиллагаа болон хөгжлийн бодлогын баримт бичигт төлөвлөлт, явц, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, үр дүнг тооцох тогтолцоог бэхжүүлнэ.

4.1.6.Багийн Засаг дарга нарын ажиллах орчин нөхцөл, тоног төхөөрөмжийг сайжруулж, нийгмийн ажилтантай болгох, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.1.7.Иргэд, төр төсвийн байгууллагын ажилтнуудад зориулсан хувь хүний хөгжил, амьдрах ухааны сургалтыг мэргэжлийн чадварлаг багш нарын оролцоотойгоор зохион байгуулна.

4.1.8.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газраас улирал бүр иргэдтэй уулзалт зохион байгуулж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч ажиллана.

4.1.9.Суманд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагын удирдлагын зөвлөгөөнийг сар бүр зохион байгуулж, цаг үеийн мэдээллийг танилцуулан, тайланг сонсож хэлэлцэнэ.

4.1.10. Сумын ИТХ, ЗДТГ-с зохион байгуулсан ажлын талаар жил бүр товхимол гаргаж өрх бүрт хүргэнэ.

4.1.11. Сумын ЗДТГ, төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагуудаас дотоодын аймаг сум байгууллага, гадаад улс орнуудын туршлага судлах, хамтын үйл ажиллагааг өргөжүүлэх ажлыг зохион байгуулна.

4.1.12.Нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулж, уулзалт зохион байгуулна.

4.2.Хууль эрх зүй:

Хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журмыг хангах ажлыг дээшлүүлж, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангана.

4.2.1.Хууль сурталчлах, таниулах ажлын хүрээнд сургалт, сурталчилгаа зохион байгуулж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг цахим болон гарын авлага, мэдээллийн самбараар шуурхай хүргэнэ.

4.2.2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.

4.2.3.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нийтэд түгээн авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх хандлагыг төлөвшүүлнэ.

4.2.4.Бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгож, иргэн бүрийн аюулгүй байдлаа хангах мэдлэг, мэдээллийг нийгэмд түгээн, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.2.5.Өмчийн хулгай, малын хулгай, байгаль орчны эсрэг гэмт хэргийн гаралтыг бууруулж, илрүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллана.

4.2.6.Хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сургууль цэцэрлэгийн орчинд гэрэлтүүлэг, гарц, камер, хурд сааруулагчтай болгох ажлыг хэрэгжүүлнэ.

4.2.7."Нэг иргэн, нэг бүртгэл" арга хэмжээг үргэлжлүүлэн улсын бүртгэлийн мэдээллийг цахимаар авах боломж нөхцөлийг суманд бүрдүүлнэ.

4.2.8.Архивын өрөөний тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.

4.3. Батлан хамгаалах бодлого,гамшгаас хамгаалах:

Орон нутгийн хамгаалалт, батлан хамгаалах, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлнэ.

4.3.1.Цэргийн насны залуучуудыг алба хаах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

4.3.2.Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийг иргэд, олон нийтэд сурталчлан, таниулах ажлыг зохион байгуулж, бүх нийтийн оролцоотойгоор орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах, хамгаалах олон талт арга хэмжээг авч, хэрэгжүүлнэ.

4.3.3.Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын үүрэг хариуцлагыг өндөржүүлнэ.

4.3.4.Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд бүх нийтийн оролцоо, Гамшгаас хамгаалах штабын бэлэн байдлыг ханган, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ.

4.3.5.Ахуйн гал түймрийг унтраах техник хэрэгсэлтэй болно.

4.3.6.Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх онцгой байдлын тасаг, нэгж байгуулах асуудлыг холбогдох газарт уламжлан шийдвэрлэх. /АЗҮАХ 4.1.12/

ТАВ. НОГООН ХӨГЖИЛ

5.1.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ногоон хөгжлийн үзэл санааг төлөвшүүлэх, хандлага, дадлыг эзэмшүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

5.2."Ногоон сум" хөдөлгөөний хүрээнд айл өрх, аж ахуйн нэгж байгууллага бүрийг мод бут сөөг тарих, зүлэгжүүлэх, ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

5.3.Сум дундын Ойн ангитай хамтран ховор зүйлийн модлог ургамлыг тарималжуулах ажлыг зохион байгуулна.

5.4.Сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, сумын 100 жилийн ойг тохиолдуулан цэцэрлэгт хүрээлэнг шинээр бий болгох.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧОО**

2021.01.25

Хуурч

№	Заалт зорилтын агуулга	Зорилтын тоо
НЭГ. “КОВИД-19” БОЛОН БУСАД ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО		11
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО		61
1.	2.1. Эрүүл мэнд	12
2.	2.2. Боловсрол	14
3.	2.3. Биеийн тамир спорт	9
4.	2.4. Соёл, урлаг	8
5.	2.5. Хүүхэд, залуучууд, гэр бүлийн бодлого	9
6.	2.6. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал	9
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО		66
1.	3.1. Хөдөө аж ахуйн бодлого	23
2.	3.2. Байгал орчин, аялал жуулчлал	10
3.	3.3. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ	5
4.	3.4. Хөрөнгө оруулалт, дэд бүтэц	21
5.	3.5. Санхүү төсвийн зохицуулалт	7
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО		26
1.	4.1. Нутгийн захиргаа	12
2.	4.2. Хуул эрх зүй	8
3.	4.3. Батлан хамгаалах бодлого, гамшгаас хамгаалах	6
ТАВ. НОГООН ХӨГЖИЛ		4
Бүгд		168